



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/510

Мөрөн сум

Бүх нийтийн хог цэвэрлэгээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.4, 9.4.5, 9.4.6, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02, 05 албан даалгавар, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 07 албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, малын сэг зэмийг халдваргүйжүүлэн устгах ажлыг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.
2. Хог хаягдлыг цэвэрлэх ажлын ерөнхий удирдамжийг нэгдүгээр, тайлан ирүүлэх хүснэгтийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Аймгийн хэмжээнд нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлын хүрээнд сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.
4. Хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сум бүр нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, бүх нийтийн их цэвэрлэгээнээс гарсан дахивар хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаяхгүйгээр “Аз Тулгатан Хаасууд” ХХК-д тушаах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.
6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
10 дугаар сарын 04-ний өдрийн
А/5.10 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

**БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ АЖЛЫН
УДИРДАМЖ**

Зорилго. Хог хаягдлын тухай хуулийн 9.4.3, 9.4.5, 9.4.6, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны 02 албан даалгавар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 07 албан даалгавруудын хэрэгжилтийг хангах, байгалиа дээдэлсэн, дарж булах хогны хэмжээг тогтмол бууруулсан, тогтвортой хөгжсөн аймаг болоход иргэдийн ухамсар мэдлэгийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшил суулгахад оршино.

Хугацаа: 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр

Зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сумдын Засаг даргын Тамгын газар

Хамрах хүрээ: Аймгийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, албан байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газар, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага оролцоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдал, усан сан бүхий газрын эрүүл хамгаалалтын бүсэд болон авто замын дагуух хуримтлагдсан малын сэг зэмийг халдваргүйжүүлэн устгах, хог хаягдлыг цэвэрлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийг татан оролцуулж бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах,

2. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбай, сад, цэцэрлэгт хүрээлэнгийн хогийг цэвэрлэх, хашаа, хайсны өнгө үзэмжийг сайжруулах, засах, угааж цэвэрлэх;

3. Хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нөлөөллийн ажил зохион байгуулах;

4. Бүх нийтийн их цэвэрлэгээнээс гарсан дахивар хог хаягдлыг тусад нь ангилан ялгаж, Аз Тулгатан Хаасууд ХХК /Утас:95053015/-д тушааж ажиллах, энэхүү үйл ажиллагааг сумдынхаа цахим хаягаар сурталчлан үр дүнтэй зохион байгуулах,

Тайлан мэдээ ирүүлэх: Сумын хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хавсралт 2-ын дагуу файлаар ирүүлнэ үү.

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

ХҮСНЭГТ

БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭНИЙ ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ЗАГВАР ХҮСНЭГТ

[illegible]